



Гепатит В гэж юу вэ?

Гепатит В бол гепатит В вирусаар үүсдэг элэгний ноцтой халдвар юм. Энэ нь хэдхэн долоо хоног үргэлжлэх хөнгөн өвчин байж болно эсвэл насан туршийн ноцтой өвчин ч байж болно.

Архаг гепатит В-тэй 4 хүн тутмын 1 нь элэгний ноцтой асуудал бүр хорт хавдартай хүртэл болдог, гэхдээ эрт илрүүлэлт, эмчилгээ болон хяналт боломжтой байдаг.


Гепатит В яаж тархдаг вэ?

Гепатит В нь хүнээс хүнд халдвартай цус эсвэл биеийн ямарваа шингэнээр дамжин тархдаг. Энэ өвчин дараах байдлаар дамжиж болно:

- Төрөх явцад жирэмсэн эхээс хүүхдэд
- Гепатит В-тэй хүний цусанд хүрснээр
- Гепатит В-тэй хүнтэй сойз, сахлын хутга, хумсны хутга эсвэл эмнэлгийн хэрэгсэл (глюзок хянагч зэрэг) гэх мэт хувийн ариун цэврийн зүйлсийг хуваалцах
- Бэлгийн харилцаа
- Зүү, тариур эсвэл мансууруулах бодис бэлтгэх төхөөрөмжийг хуваалцах

Гепатит В нь дараах арга замаар ТАРХДАГГҮЙ:

- Хоол хүнс эсвэл аяга тавгаа хуваалцах
- Тэврэх, үнсэх эсвэл гар барих
- Ус эсвэл агаараар



Дэлгэрэнгүй мэдээлэл авах:

Centers for Disease Control and Prevention (CDC/ӨХУСТ, Өвчний Хяналт, Урьдчилан Сэргийлэлтийн Төвүүд)
www.cdc.gov/hepatitis/hbv/



DOH 420-405 May 2022 Mongolian
Энэ баримт бичгийг өөр форматаар авах бол 1-800-525-0127 руу залгана уу. Дүлий эсвэл сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчид, 711 (Washington Relay) руу залгана уу эсвэл civil.rights@doh.wa.gov руу э-мэйл бичнэ үү.
Эх сурвалж: Minnesota Department of Health, Hepatitis B

Гепатит В: Хүн бүр юуг мэдэх ёстой вэ





ХЭН ШИНЖИЛГЭЭ ӨГӨХ ЁСТОЙ ВЭ?

Та гепатит В-тэй эсэхээ мэдэх цорын ганц арга нь шинжилгээ өгөх юм.

- Бүх жирэмсэн эхчүүд гепатит В-ийн шинжилгээг тогтмол өгч байх ёстой. Хэрэв жирэмсэн эх гепатит В-тэй бол цаг тухайд нь вакцин хийлгэснээр вирусыг хүүхэддээ халдаахаас сэргийлнэ.
- Гепатит В-тэй хүнтэй хамт амьдардаг хүмүүс.
- Гепатит В-ийн нэмэлт эрсдэлтэй хүмүүс үүнд дараах хүмүүс багтана:
 - Гепатит В илүү түгээмэл байдаг Африк эсвэл Ази зэрэг газар нутагт төрсөн хүмүүс, эсвэл эцэг эх нь эдгээр газарт төрсөн
 - Мансууруулах бодис тарьдаг хүмүүс
 - Эрэгтэй хүнтэй бэлгийн харилцаанд ордог эрэгтэйчүүд



Хэн вакцин хийлгэх ёстой вэ?

Centers for Disease Control and Prevention (CDC/ӨХУСТ, Өвчний Хяналт, Урьдчилан Сэргийлэлтийн Төвүүд) нь гепатит В-ийн вакциныг ихэнх хүмүүст зөвлөдөг, үүнд:

- Бүх нялх хүүхдүүд
- Эрсдлийн хүчин зүйлээс үл хамааран 59 хүртэлх насны вакцин хийлгээгүй бүх хүүхэд, насанд хүрэгчид
- 60 ба түүнээс дээш насны дараах төрлийн эрсдлийн хүчин зүйлтэй хүмүүс:
 - Бэлгийн харилцаанд орсноор халдвар авах эрсдэлтэй хүмүүс
 - Арьсны болон салст бүрхэвчээр цусаар дамжин халдварлах эрсдэлтэй хүмүүс
 - Гепатит В-ийн дунд зэргийн эсвэл дээд зэргийн халдварын тохиолдол бүхий газар нутаг руу аялах
 - Элэгний архаг өвчтэй хүмүүс
 - ХДХВ-ийн халдвартай хүмүүс
 - Хоригдож байгаа хүмүүс
 - Гепатит В-с хамгаалагдахаар эрэлхийлж байгаа бусад бүх хүмүүс



Дэлхий даяар ойролцоогоор 296 сая хүн гепатит В-тэй амьдарч байгаа ч олон хүн өвдөж мэдрэгдэх эсвэл харагддаггүй тул халдвар авсан гэдгээ мэддэггүй.



Вакцин аюулгүй юу?

Гепатит В-ийн вакцин аюулгүй бөгөөд үр дүнтэй. Үүнийг 1982 оноос хойш АНУ-д хэрэглэж байна.

Гепатит В-ийн вакцины нэг тэрбумаас их тунг дэлхий даяар өгөөд байна.

Вакцинд үзүүлэх хамгийн түгээмэл хариу урвал нь бага зэрэг эсвэл дунд зэрэг халуурах, тариулсан газарт өвдөх явдал юм. Эдгээр үр нөлөө 1-2 өдөр үргэлжилж болно.



Гепатит В-ийн вакциныг хаана хийлгэх вэ?

Вакцин хийлгэх талаар эмийн сан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эсвэл орон нутгийн эрүүл мэндийн хэлтэстэйгээ ярилцаарай. Зарим эмнэлгүүд үнэгүй эсвэл бага зардалтай гепатит В-ийн вакциныг санал болгодог.

Эрүүл мэндийн даатгалаар 59 хүртэлх насны бүх хүмүүс, эрсдэлт хүчин зүйлтэй 60-аас дээш насны хүмүүс вакцинд хамрагдаж болно.

Хэрэв та хүүхэд төрүүлвэл та эмнэлгээс гарахын өмнө хүүхэддээ гепатит В-ийн вакциныг хийлгэж болно. Вакциныг шинээр мэндэлсэн хүүхдүүдэд төлбөргүй хийдэг.